



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/117

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 24, 2023 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Зөгийн үүр хөтөлбөрийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2024 оны 01 дүгээр улирлын төрийн албаны ерөнхий шалгалтад бүртгүүлсэн иргэдэд дэмжлэг үзүүлэх тактикийн сургалтыг "EASY" цахим сургалтын төвтэй хамтран танхимын болон цахим сургалтын зардалд 1,760,000 (нэг сая долоон жаран мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Сургалтын зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Зөгийн үүр хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ